



ХҮНИЙ БЭЛГИЙН ЭРХ ЧӨЛӨӨ, ХАЛДАШГҮЙ БАЙДЛЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГТ ХОХИРСОН ХҮҮХДҮҮД, ХЭРГИЙН ШИЙДВЭРЛЭЛТ

- БАРИМТЫН ДҮН ШИНЖИЛГЭЭ -

МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИСС

2020 ОН

УЛААНБААТАР ХОТ

Агуулга

Танилцуулга.....	3
НЭГ. ХҮНИЙ БЭЛГИЙН ЭРХ ЧӨЛӨӨ, ХАЛДАШГҮЙ БАЙДЛЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГТ ХОХИРСОН ХҮҮХДҮҮД.....	4
ХОЁР. ХҮҮХЭДТЭЙ ХОЛБООТОЙ ХҮНИЙ БЭЛГИЙН ЭРХ ЧӨЛӨӨ, ХАЛДАШГҮЙ БАЙДЛЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРГИЙН ШИЙДВЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ.....	8

Танилцуулга

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу тус Комисс нь бүрэн эрхийнхээ хүрээнд мөн зүйлийн 13.2.1-д заасны дагуу хүний эрхийн асуудлаар судалгаа явуулж, шаардлагатай мэдээллээр хангах үйл ажиллагааг хэрэгжүүлдэг болно.

Комисс нь Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээгээр хамгаалагдсан хүүхдийн эрх, эрх чөлөөний нөхцөл байдалд судалгаа хийж байгаа бөгөөд энэ хүрээнд Монгол Улсын хэмжээнд өсвөр үеийнхний БЗДХ-ын өвчлөл, өсвөр насны охидын төрөлт, үр хөндөлт, ураг зулбалт, эх хүүхдийн эндэгдэл болон хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл, мөлжлөг, нөхөн үржихүйн эрхийн эсрэг гэмт хэргийн мэдээлэл зэргийг холбогдох байгууллагуудаас гаргуулан авч, тэдгээрт дүн шинжилгээ хийв.

Энэхүү дүн шинжилгээг Улсын Ерөнхий Прокурорын газар, Цагдаагийн ерөнхий газраас тус тус ирүүлсэн мэдээлэлд үндэслэн гаргав.

Зорилтот бүлэг: 0-18 хүртлэх насны хүүхэд

Хамрах хүрээ: Улсын хэмжээнд

Цаг хугацааны хамаарал: 2018-2019 он

Уг дүн шинжилгээнд тоон мэдээлэлд харьцуулалт хийх аргыг хэрэглэв.

НЭГ. ХҮНИЙ БЭЛГИЙН ЭРХ ЧӨЛӨӨ, ХАЛДАШГҮЙ БАЙДЛЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГТ ХОХИРСОН ХҮҮХДҮҮД

2019 онд улсын хэмжээнд хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг нийт 610¹ гэмт хэрэг бүртгэгдсэн байна. Эдгээр гэмт хэрэгт 624 хохирогч бүртгэгдсэнээс 359 нь буюу 57.53 хувь нь хүүхэд байна. Тухайлбал, бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэргийн 5 хохирогчийн 3 нь, бэлгийн мөлжлөг гэмт хэргийн 6 хохирогчийн 4 нь, хүчиндэх гэмт хэргийн 492 хохирогчийн 253 нь хүүхэд байна.

“Улсын хэмжээнд бүртгэгдсэн хүчиндэх гэмт хэргийн хохирогчийн 51.42 хувь нь хүүхэд байна.”

Цагдаагийн ерөнхий газраас Комисст ирүүлсэн мэдээллээс дүгнэж үзвэл орон нутагт Хангайн бүс (тэр дундаа Хөвсгөл), Төвийн бүс (Сэлэнгэ, Дорноговь)-ийн аймгууд, Нийслэлд Сонгинохайрхан, Баянзүрх, Сүхбаатар дүүргүүдэд хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт хүүхэд хохирогч болсон тохиолдол харьцангуй олон бүртгэгджээ. (Хүснэгт 1)

Хүснэгт 1. Хүний бэлгийн болон эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч хүүхдийн тоо (аймаг, нийслэлээр)

	Хүчиндэх (§12.1)		Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах (§12.2)		Бэлгийн мөлжлөг (§12.3)		Арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох (§12.5)		Нийт	
	2018	2019	2018	2019	2018	2019	2018	2019	2018	2019
УЛСЫН ДҮН	238	253	9	3	1	4	64	99	312	359
Баруун бүс	21	27	-	-	-	-	2	6	23	33
Баян-Өлгий	4	4	-	-	-	-	-	-	4	4
Говь-Алтай	-	1	-	-	-	-	-	-	-	1
Завхан	2	6	-	-	-	-	-	1	2	7
Увс	11	12	-	-	-	-	1	2	12	14
Ховд	4	4	-	-	-	-	1	3	5	7
Хангайн бүс	49	57	2	-	-	-	25	41	76	98
Архангай	5	6	-	-	-	-	-	1	5	7
Баянхонгор	9	10	2	-	-	-	2	14	13	24
Булган	3	10	-	-	-	-	-	-	3	10
Орхон	14	10	-	-	-	-	18	-	32	10
Өвөрхангай	7	4	-	-	-	-	3	16	10	20
Хөвсгөл	11	17	-	-	-	-	2	10	13	27

¹ Цагдаагийн ерөнхий газраас ХЭҮК-т 2020.01.20-нд ирүүлсэн дүн мэдээ.

Төвийн бүс	50	54	1	1	-	-	10	26	61	81
Говьсүмбэр	2	3	-	-	-	-	-	-	2	3
Дархан-Уул	9	3	-	-	-	-	2	-	11	3
Дорноговь	12	15	-	-	-	-	1	6	13	21
Дундговь	3	2	-	-	-	-	3	2	6	4
Өмнөговь	5	7	-	-	-	-	-	10	5	17
Сэлэнгэ	6	22	1	-	-	-	4	8	11	30
Төв	13	2	-	1	-	-	-	-	13	3
Зүүн бүс	23	18	-	-	-	-	5	5	28	23
Дорнод	7	8	-	-	-	-	3	1	10	9
Сүхбаатар	4	7	-	-	-	-	-	-	4	7
Хэнтий	12	3	-	-	-	-	2	4	14	7
Нийслэл	95	97	6	2	1	4	22	21	124	124
Баянгол	12	7	2	2	-	-	1	4	15	13
Баянзүрх	27	25	2	-	-	1	7	6	36	32
Сүхбаатар	6	12	1	-	1	-	-	1	8	13
Сонгинохайрхан	32	34	-	-	-	2	6	3	38	39
Хан-Уул	4	6	-	-	-	-	1	2	5	8
Чингэлтэй	8	11	-	-	-	1	4	2	12	14
Багануур	4	2	-	-	-	-	3	-	7	2
Багахангай	-	-	-	-	-	-	-	-	-	-
Налайх	2	-	1	-	-	-	-	3	3	3


Сүүлийн 2 жилийн байдлаар хүчиндэх буюу Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйлд заасан гэмт хэрэгт хохирогчоор тогтоогдсон хүүхдүүдийн тоо хамгийн их (нийт хохирсон хүүхдүүдийн 73.17%) байна. Насаар ангилан авч үзвэл, 2018 оны байдлаар 14-17 насны хүүхэд 62.4 хувийг, 8-13 насны хүүхэд 31 хувийг, 7 хүртэлх насны хүүхэд 6.6 хувийг, харин 2019 оны байдлаар 14-17 насны хүүхэд 50.6 хувийг, 8-13 насны хүүхэд 37.94 хувийг, 7 хүртэлх насны хүүхэд 11.46 хувийг тус тус эзэлж байгаа буюу 2018 оны үзүүлэлтээс насны хувьд залуужсан байна. (График 1)

График 1. 0-17 хүртэлх насны хохирогч хүүхдийн тоог гэмт хэрэгт тус бүрт, насны ангиллаар харьцуулсан нь

(2018 он)



(2019 он)



2018 оны дүнгээр дээрх гэмт хэргүүдийн 91.5 (184 хүн) хувийг гэр бүлийн гишүүн биш этгээд, 3.4 хувийг хойд эцэг нь үйлдсэн бол 2019 оны байдлаар 88.9 (209 хүн) хувийг гэр бүлийн гишүүн биш этгээд, 4.6 хувийг хойд эцэг нь үйлдсэн байна. (Хүснэгт 2)


Хүснэгт 2. “Хүний бэлгийн болон эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг” гэмт хэргийн хүчирхийлэл үйлдэгч этгээдийн ангилал, тоон мэдээлэл

	Хүчиндэх (§12.1)		Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах (§12.2)		Бэлгийн мөлжлөг (§12.3)		16 насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох (§12.5)		Нийт	
	2018	2019	2018	2019	2018	2019	2018	2019	2018	2019
Төрсөн эцэг	3	5	-	-	-	-	-	-	3	5
Хойд эцэг	7	11	-	-	-	-	-	-	7	11
Хойд эх	-	1	-	-	-	-	-	-	-	1
Үрчилсэн эцэг	-	-	-	1	-	-	-	-	-	1
Хүргэн	1	3	-	-	-	-	1	-	2	3
Төрөл садан	5	2	-	-	-	-	-	1	5	3
Төрсөн ах	-	2	-	-	-	-	-	-	-	2
Бусад	144	147	6	-	1	1	33	61	184	209
Нийт дүн	160	171	6	1	1	1	34	62	201	235


Цагдаагийн ерөнхий газраас 2018 онд хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг нь хүүхдийн бэлгийн эрх чөлөөний эсрэг үйлдэгдсэн нийт гэмт хэргийн 76.2 хувийг эзэлж байсан бол 2019 онд 78.8 хувийг эзэлж байна (График 2) гэж, харин Монгол Улсын Ерөнхий прокурорын газраас 2018 онд дээрх тоо 76.4 хувь байсан бол 2019 онд 43.3 хувь болсон талаар тус тус мэдээлсэн байна. (График 3)

График 2. Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэргийн статистик

(2018 он)




(2019 он)



ХОЁР. ХҮҮХЭДТЭЙ ХОЛБООТОЙ ХҮНИЙ БЭЛГИЙН ЭРХ ЧӨЛӨӨ, ХАЛДАШГҮЙ БАЙДЛЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРГИЙН ШИЙДВЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ

2019 онд хүүхэдтэй холбоотой хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг нийт 616² хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэн шалгасан нь 2018 оны мэдээлэлтэй³ харьцуулахад бараг 2 дахин нэмэгдсэн байна.⁴ (График 3)

График 3. Хүүхэдтэй холбоотой хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэсэн байдал



Дээрх гэмт хэргүүдийн шийдвэрлэлтийн байдлаас харахад 2018 онд нийт эрүүгийн хэрэг үүсгэн шалгасан тохиолдлын 49 хувийг (159 *тохиолдлыг*), 2019 онд 14.8 хувийг (91 *тохиолдлыг*) шүүхэд шилжүүлж шийдвэрлүүлсэн байна. (Хүснэгт 3)

²Монгол Улсын Ерөнхий Прокурорын газраас ХЭҮК-т 2020.01.22-нд ирүүлсэн дүн мэдээ.

³2018 онд хүүхэдтэй холбоотой хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг нийт 324 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэн шалгасан байна.


⁴ Улсын Ерөнхий Прокурорын газраас харьяа Прокурорын газруудаар дамжуулан холбогдох эмнэлгийн байгууллагуудаас 2019 оны байдлаар 18 насанд хүрээгүй хүн жирэмсэн болсон, үр хөндүүлсэн, хүүхэд төрүүлсэн талаарх судалгааг гаргуулан үзэхэд насанд хүрээгүй хүн жирэмслэж хүүхэд төрүүлсэн, үр хөндүүлсэн 1352 тохиолдол илэрсэн болно. Эдгээр тохиолдлуудыг цагдаагийн байгууллагуудаар шалгуулан ажилласны үр дүнд “Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн нуугдмал гэмт хэрэг”-ийн нөхөн илрүүлэлт нэмэгдсэн байна. Ийм учраас өмнөх онтой харьцуулахад 2019 онд эрүүгийн хэрэг үүсгэн шалгасан гэмт хэргийн тоо өссөн байна.

Хүснэгт 3. Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэргийн шийдвэрлэлтийн ерөнхий байдал

	Хүчиндэх (§12.1)		Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах (§12.2)		Бэлгийн мөлжлөг (§12.3)		Арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох (§12.5)	
	2018	2019	2018	2019	2018	2019	2018	2019
Хэрэг бүртгэлийг хаасан	85	90	2	-	1	2	27	281
Ажиллагаанд байгаа	30	95	-	1	1	3	3	33
Нэгтгэгдсэн	-	5	-	-	-	-	-	4
Хэрэгсэхгүй болгосон	9	7	-	1	-	-	2	3
Шүүхэд шилжүүлсэн	126	70	3	1	-	-	35	20

Тодорхой гэмт хэргүүдийн шийдвэрлэлтийн байдал:

График 4. Хүчиндэх гэмт хэрэг (2018 он)



(2019 он)





График 5. Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэрэг (2018 он)



(2019 он)





График 6. Бэлгийн мөлжлөг гэмт хэрэг

(2018 он)




(2019 он)




График 7. 16 насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох гэмт хэрэг

(2018 он)



(2019 он)



2018 онд хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй холбоотой 11 хэргийг, 2019 онд 12 хэргийн доорх үндэслэлээр хэрэгсэхгүй болгосон байна. (Хүснэгт 4)

“Хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдийн 47.2 хувь нь 26-45 насны хүмүүс байна.”

Хүснэгт 4. Хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэргийн статистик

	Хүчиндэх (§12.1)		Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах (§12.2)		Бэлгийн мөлжлөг (§12.3)		Арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох (§12.5)	
	2018	2019	2018	2019	2018	2019	2018	2019
Гэмт хэргийн шинжгүй	5	2	-	-	-	-	-	1
Сэжигтэн, яллагдагч нас барсан	-	-	-	-	-	-	-	-


Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дууссаны дараа эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан	1	-	-	1	-	-	-	-
Гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдсон боловч ял оногдуулах насанд хүрээгүй	3	5	-	-	-	-	1	3

График 8-аас харвал сүүлийн 2 жилийн хугацаанд 18-45 насны бүлгийнхэн дээрх гэмт хэрэгт яллагдагчаар илүүтэй татагдан шалгагдсан байна. Тухайлбал, 2019 оны байдлаар эрүүгийн хэрэг үүсгэн шалгасан 616 хүчиндэх гэмт хэргийн 48-т нь 18-25 насны, 69-д нь 26-45 насны хүмүүс яллагдагчаар татагдсан байна.


Тэгвэл хүүхэдтэй холбоотой хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг хэрэгт 22 хүүхэд яллагдагчаар татагдан шалгагдсан нь 15 хувийг эзэлж байна. (График 8)

График 8. Хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэргийн сэжигтэн, яллагдагч нарын мэдээлэл

(2018 он)



(2019 он)




Мөн адил сүүлийн 2 жилийн мэдээллийг дүгнэхэд 13-15 насны хүүхдүүд бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэг, тэр дундаа хүчиндэх болон арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох гэмт хэргийн хохирогчдын дийлэнх хувийг эзэлж байна. 2018 онд хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогчоор тогтоогдсон хүүхдүүдийн хамгийн бага нь 1 настай байсан бол 2019 онд хохирогчоор тогтоогдсон хүүхдүүдийн хамгийн бага нь 2 настай байна. (График 9)


График 9. Хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэргийн хохирогч хүүхдүүдийн мэдээлэл (Насны ангиллаар)

(2018 он)

“2018 онд 13-15 насны хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэгт хохирогчоор тогтоогдсон хүүхдийн тоо 157 байсан бол 2019 онд 411 болж өссөн байна.




(2019 он)




Түүнчлэн 2017 онд хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэргийн улмаас хохирсон нийт 262 хүүхдийн 126 нь буюу 48.1 хувийг 16-17 насныхан эзэлж байсан бол 2018 оны хувьд хохирсон нийт 350 хүүхдийн 101 нь буюу 28.8 хувийг 16-17 насныхан эзэлж байна. (График 10)

График 10. Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэргийн улмаас хохирсон хүүхдүүдийн насны мэдээлэл

(2018 он)



(2019 он)



Тойм дүгнэлт

ЦЕГ-аас Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисст ирүүлсэн мэдээллээс үзэхэд 2019 онд улсын хэмжээнд бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг нийт 610 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх онтой харьцуулахад 10 тохиолдлоор буурсан үзүүлэлт юм. Мөн уг төрлийн гэмт хэргийн гаралт буурсан хэдий ч 18 насанд хүрээгүй хүүхдүүд хохирогчоор бүртгэгдэх тохиолдол нэмэгдсээр байна. Тодруулбал, Эрүүгийн хуулийн 12-р бүлэгт заасан “Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг”-т 2018 онд 579 хохирогч бүртгэгдсэнээс 312 нь хүүхэд байсан бол 2019 онд 624 хохирогч бүртгэгдсэнээс 359 нь хүүхэд байна.

Эрүүгийн хуулийн 12-р бүлгийг зүйл бүрээр нарийвчлан авч үзвэл, 2019 онд хүчиндэх (ЭХ-ийн §12.1) гэмт хэргийн 492 хохирогчийн 253 нь, бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах (ЭХ-ийн §12.2) гэмт хэргийн 5 хохирогчийн 3 нь, бэлгийн мөлжлөг (ЭХ-ийн §12.3) гэмт хэргийн 6 хохирогчийн 4 нь хүүхэд байна. Харин арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох (ЭХ-ийн §12.5) гэмт хэргийн хохирогч 99 хүүхэд байна.

Цагдаагийн ерөнхий газраас 2018 онд хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг нь хүүхдийн бэлгийн эрх чөлөөний эсрэг үйлдэгдсэн нийт гэмт хэргийн 76.2 хувийг эзэлж байсан бол 2019 онд 78.8 хувийг эзэлж байна гэж, харин Улсын Ерөнхий прокурорын газраас 2018 онд дээрх тоо 76.4 хувь байсан бол 2019 онд дээрх тоо 43.3 хувь болсон хэмээн тус тус мэдээлсэн байна. Эрүүгийн хуулийн §12.5-т заасан гэмт хэргийн хувь огцом (Бэлгийн эрх чөлөөний эсрэг үйлдэгдсэн нийт гэмт хэргийн 55.3 хувь) нэмэгдсэн нь дээр дурдсанчлан Улсын Ерөнхий Прокурорын газраас явуулсан шалгалтын дүнтэй холбоотой юм.

Хохирогч хүүхдүүдийн насны ангиллыг харгалзан үзэхэд, 13-15 насны хүүхдүүд дийлэнх хувийг эзэлж байна. Сүүлийн 2 жилийн хугацаанд 18-45 насныхан хүчиндэх гэмт хэрэгт яллагдагчаар илүүтэй татагдан шалгагдсан байна. Тухайлбал, 2018 онд эрүүгийн хэрэг үүсгэн шалгасан 251 хүчиндэх гэмт хэргийн 62-т нь 18-25 насны хүмүүс, 89-д нь 26-45 насны хүмүүс яллагдагчаар, 2019 онд

267 хүчиндэх гэмт хэргийн 35-д нь 18-25 насны хүмүүс, 54-т нь 26-45 насны хүмүүс яллагдагчаар тус тус татагдсан байна.

Харин 2018 онд хүүхэдтэй холбоотой хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг хэрэгт 29 хүүхэд (нийт яллагдагчдын 12.5 хувь), 2019 онд 17 хүүхэд (нийт яллагдагчдын 15.1 хувь) яллагдагчаар татагдан шалгагдсан ба 2018 онд хохирогчоор тогтоогдсон хүүхдүүдийн хамгийн бага нь 1 настай байсан бол 2019 онд хохирогчоор тогтоогдсон хүүхдийн хамгийн бага нь 2 настай байна.

ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИСС
ХҮНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛ, СУДАЛГААНЫ ХЭЛТЭС